

ᠳᠣᠷᠨᠣᠳ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ  
ᠠᠤᠳᠢᠲᠤ ᠶᠡᠨ ᠭᠠᠰᠠᠷ  
ᠳᠣᠷᠨᠣᠳ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ  
ᠲᠦᠰᠦ᠋᠋᠋᠋᠋᠋ ᠲᠦᠰᠦ᠋᠋᠋᠋᠋ ᠲᠦᠰᠦ᠋᠋᠋᠋᠋  
ᠲᠦᠰᠦ᠋᠋᠋᠋᠋ ᠲᠦᠰᠦ᠋᠋᠋᠋᠋ ᠲᠦᠰᠦ᠋᠋᠋᠋᠋  
ᠲᠦᠰᠦ᠋᠋᠋᠋᠋ ᠲᠦᠰᠦ᠋᠋᠋᠋᠋ ᠲᠦᠰᠦ᠋᠋᠋᠋᠋

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР



**ДОРНОД АЙМГИЙН  
2022 ОНЫ ТӨСВИЙН  
ТӨСӨЛД ӨГСӨН  
АУДИТЫН ДҮГНЭЛТ**

2021 он

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгт, дүрслэлийн товъёг .....	4
Зорилт, хамарсан хүрээ, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5-6
<b>Бүлэг 1.</b> Төсвийн орлого, зарлагын хязгаар.....	7
<b>Бүлэг 2.</b> Төсвийн орлогын төлөвлөлт.....	8-9
<b>Бүлэг 3.</b> Төсвийн зарлагын төлөвлөлт.....	9-11
<b>Бүлэг 4.</b> ТЭЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшин	
4.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт .....	11-12
4.2. Хөрөнгө оруулалтын бус төсөл, хөтөлбөр.....	12-13
4.3. Орон нутгийн хөгжлийн сан.....	13-15
<b>Бүлэг 5.</b> Сангийн зардлууд	
5.1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал.....	16-19
5.2. Авто замын сан.....	20
5.3. Халамжийн сан .....	21-22
Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ .....	22-23
Дүгнэлт.....	23
<b>Төсвийн төсөлд өгөх санал.....</b>	<b>23</b>
Аймгийн ИТХ-ын хариу.....	

## Товчилсон үгийн тайлбар

БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОХНСЗ	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЗЗННТУТХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

### Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Сангийн яамны орлогын хянасан хязгаар болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын харьцуулалт	7
Хүснэгт 2	Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого	8
Хүснэгт 3	Төсвийн орлогын хязгаар	9
Хүснэгт 4	Сангийн яамны зарлагын хянасан хязгаар болон орон нутгийн төсвийн төслийн зарлагын харьцуулалт	10-11
Хүснэгт 5	Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журамд нийцээгүй төсөл, хөтөлбөрийн жагсаалт	13
Хүснэгт 6	Үр ашгийг сайжруулах төсөл, арга хэмжээ	14
Хүснэгт 7	Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д заасан төсөвлөлтийн шалгуурт нийцээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт	15
Хүснэгт 8	Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх	16
Хүснэгт 9	Хуулиар зөвшөөрсөн зарцуулах хувь, хэмжээ	16-17
Хүснэгт 10	Хуулиар зарцуулах хувь, хэмжээг төсвийн төсөлтэй харьцуулсан харьцуулалт	17
Хүснэгт 11	Жагсаалтаас хасах саналтай төсөл, арга хэмжээний жагсаалт	19
Хүснэгт 12	Төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн шаардлага хангасан эсэх талаарх шинжилгээ	20
Хүснэгт 13	Зураг, төсвийн харьцуулсан шинжилгээ	21

### Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	2017 оноос хуримтлагдсан авлага	9
Дүрслэл 2	БОХНС чиглэлээр зарцуулах төсвийн харьцуулалт	17
Дүрслэл 3	БОХНСЗ-аар хийгдэх төсөл, арга хэмжээний хууль, журмын шаардлага хангасан эсэх талаарх харьцуулалт	18
Дүрслэл 4	Төсөл, арга хэмжээний тоо болон санхүүжилтийн харьцуулсан шинжилгээ	20
Дүрслэл 5	Батлагдсан төсвийг гүйцэтгэлтэй харьцуулсан байдал	22

<b>Үндэслэл, бүрэн эрх</b>	<b>Зорилт, хамарсан хүрээ, арга зүйн талаарх мэдэгдэл</b>
<b>Зорилт</b>	<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь “Монгол Улсын Засгийн газар /цаашид “Засгийн газар” гэх/-аас Монгол Улсын Их Хурал /цаашид “Улсын Их Хурал” гэх/-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд <b>төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх</b>” гэж заасны дагуу Дорнод аймгийн 2022 оны төсвийн төсөлд өгөх санал, дүгнэлтийг 2021 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс 12 дугаар сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд хийв.</p> <p>Төсвийн ерөнхийлөн захирагчийн өргөн мэдүүлсэн орон нутгийн 2022 оны төсвийн төсөл нь холбогдох шалгуур үзүүлэлтүүдэд нийцсэн эсэхийг хангахад зорилт чиглэгдлээ.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр санал, дүгнэлтийг гүйцэтгэлээ. Үүнд:</p>
<b>Хамрах хүрээ</b>	<p><i>Төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх</i> <i>Төсвийн зарлагыг бууруулах</i> <i>Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх</i></p> <p>Дорнод аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын холбогдох хэлтсүүдийг хамрууллаа.</p> <p>Аймгийн Засаг даргаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн 2022 оны жилийн төсвийн төсөл, холбогдох нотлох баримтууд болон тооцоо, судалгааг хамрууллаа.</p>
<b>Шалгуур үзүүлэлт</b>	<p>Төсвийн ерөнхийлөн захирагчийн өргөн мэдүүлсэн орон нутгийн 2022 оны төсвийн төсөл нь дараах шалгуур үзүүлэлтүүдэд нийцсэн эсэхийг авч үзлээ. Тухайлбал:</p> <ol style="list-style-type: none"><li>1. <i>Төсвийн тухай хууль</i></li><li>2. <i>Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамж</i></li><li>3. <i>МУЗЗНДНТУТХ</i></li><li>4. <i>Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль</i></li><li>5. <i>Газрын тухай хуулийн</i></li><li>6. <i>Тариалангийн тухай хууль</i></li><li>7. <i>Нийгмийн халамжийн тухай хууль</i></li><li>8. <i>Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”</i></li><li>9. <i>Сангийн Сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”</i></li><li>10. <i>Сангийн Сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”</i></li><li>11. <i>Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоол “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”</i></li><li>12. <i>Холбогдох бусад хууль, журам, заавар</i></li></ol>

**Холбогдох  
мэдээлэл**

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамжид төсвийн зарлагын удирдлагын шинэчлэлийн хүрээнд **үр дүн, нотолгоонд суурилсан, оновчтой, үр ашигтай төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх, төсвийн зарлагын шинэчлэлийг үргэлжлүүлж, төсвийн урсгал зардлыг хэмнэх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой байхаар төлөвлөлтийг хийхээр заасан.**

Төсвийн удирдлагын үндсэн зарчмууд нь төрийн шийдвэр гаргах болон хянах үе шатуудад гарч болзошгүй эрсдэлийг тодорхой хэмжээнд бууруулах, эсвэл урьдчилан сэргийлэх, чанарыг сайжруулахад чиглэгддэг.

Төсвийн тухай хуулийн 8.5.1 дэх “аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх” гэсэн заалттай.

**Гүйцэтгэсэн  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, аудиторууд хуваарийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Талбарын ажлыг 2021 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлүүлж, санал, дүгнэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга М.Энхтөрд 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хүргүүллээ.

## БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ХЯЗГААР

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас хянан ирүүлсэн хязгаарт багтаан боловсруулахаар заасан.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтад жилийн төсвийн хязгаарыг тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод, зарлагын дээд хэмжээ гэж заасан ч жилийн суурь орлогыг 8.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн төсөлд тусган ирүүлсэн байна.

1. Аймгийн 2022 оны батлагдсан төсөв дэх суурь орлогыг Сангийн яамнаас баталсан хязгаартай харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 1 (Сангийн яамны орлогын хянасан хязгаар болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын харьцуулалт)

		/мянган төгрөг/		
д/д	Үзүүлэлт	Сангийн яамны хянасан төсөв	2022 оны аймгийн төсвийн төсөл	Сангийн яамны хянасан зөрүү
<b>ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>		<b>56,709,018.8</b>	<b>64,984,605.4</b>	<b>8,275,586.6</b>
<b>ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО</b>		<b>56,709,018.8</b>	<b>64,984,605.4</b>	<b>8,275,586.6</b>
1	<b>Татварын орлого</b>	<b>37,125,000.0</b>	<b>38,025,110.5</b>	<b>900,110.5</b>
1.1	Орлогын албан татвар	30,110,000.0	30,110,000.0	-
1.2	Хөрөнгийн албан татвар	1,235,000.0	1,235,000.0	-
1.3	Бусад татвар (Төлбөр, хураамж)	5,780,000.0	6,680,110.5	900,110.5
2	<b>Татварын бус орлого</b>	<b>19,584,018.8</b>	<b>24,147,618.8</b>	<b>4,563,600.0</b>
2.1	Нийтлэг татварын бус орлого	3,283,502.0	3,079,302.0	(204,200.0)
2.2	Хөрөнгийн орлого	-	380,000.0	380,000.0
2.3	Тусламжийн орлого	-	4,387,800.0	4,387,800.0
2.4	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	16,300,516.8	16,300,516.8	-
3	<b>Харилцах дансны урьд оны үлдэгдлээс санхүүжих</b>		<b>2,811,876.1</b>	<b>2,811,876.1</b>

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2021 оны 1/2281 тоот албан бичгийн 1 дүгээр хавсралт

Дээрх орлогоос татварын орлогыг 8.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхдээ хандив тусламжийн орлогыг 4.4 тэрбум төгрөг, бусад татварын орлогыг 0.9 тэрбум төгрөг, хөрөнгийн орлогыг 0.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн, нийтлэг бус татварын орлогыг 0.2 тэрбум төгрөгөөр бууруулан, өмнөх оны харилцах дансны үлдэгдлээс 2.8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тооцсон.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь заалтад хамаарахгүй шууд бус татварын орлогыг Сангийн яамнаас аймгийн төсвийн орлогын бүрэлдэхүүн хэсэгт 1.0 тэрбум төгрөгийг хянаж орлогын төлөвлөлтөд баталсан байна.

Харин нийтлэг татварын бус орлогод хамаарах “Төсвийн байгууллагын өөрийн орлого”- ыг 0.2 тэрбум төгрөг буюу 61.2 хувиар бууруулсан нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтын “*жилийн төсвийн хязгаар*” гэж ... орлогын доод хэмжээ, ...” гэсэнтэй нийцэхгүй байна.

### ДҮГНЭЛТ:

Сангийн яамнаас төсвийн орлогын хязгаарыг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь заалтыг мөрдөн ажиллаагүй байна.

Аймгийн төсвийн орлогыг төлөвлөхдөө Сангийн яамны хянасан хязгаараас бууруулан төлөвлөсөн байна.

## САНАЛ:

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д заасны дагуу аймгийн төсвийн орлогыг Сангийн яамнаас хянасан хязгаарын дагуу батлах.

## БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д “жилийн төсвийн хязгаар” гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдээдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг” хэлнэ гэж тодорхойлсон.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Сангийн яамнаас аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогын доод хязгаарыг 40.4 тэрбум төгрөгөөр хянасныг 41.5 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэн төсвийн төсөлд тусган ирүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь татварын орлогыг 0.9 сая төгрөгөөр, татварын бус орлогын 0.2 сая төгрөгөөр, хандив тусламжийн орлогыг 4,387.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төсөвлөсөн байна.

Хүснэгт 2 (Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого)

д/д	Үзүүлэлт	2022 он		
		Сангийн яамны хянасан төсөв	Аймгийн төсвийн төсөл	Зөрүү
	<b>ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО</b>	<b>40,408,502.0</b>	<b>41,484,412.5</b>	<b>1,075,910.5</b>
1	Татварын орлого	37,125,000.0	38,025,110.5	900,110.5
2	Татварын бус орлого	3,283,502.0	3,459,302.0	175,800.0
2.3	Тусламжийн орлого	-	4,387,800.0	4,387,800.0

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2021 оны 1/2281 тоот албан бичгийн 1 дүгээр хавсралт

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын 91.7 хувийг татварын орлого, 8.3 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг төлөвлөхдөө Сангийн яамнаас ирүүлсэн орлогын доод хязгаарыг баримтлан төлөвлөсөн хэдий ч татварын орлогын ХХОАТ-ыг 1,000.0 сая, татварын бус төсөвт байгууллагын өөрийн орлого /үндсэн/ 204.2 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь “Жилийн төсвийн хязгаар” гэж “Төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдээдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээг, ...”, 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь “жилийн төсвийн хязгаарт багтаасан байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

д/д	Үзүүлэлт	2022 он		Зөрүү
		Сангийн яамны хянасан төсөв	Аймгийн төсвийн төсөл	
<b>ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО</b>		<b>40,408,502.0</b>	<b>41,484,412.5</b>	<b>(1,075,910.5)</b>
1	Татварын орлого	37,125,000.0	38,025,110.5	(900,110.5)
1.1	Орлогын албан татвар	30,110,000.0	30,110,000.0	-
1.1.1.7	Шууд бус орлого	1,000,000.0	-	1,000,000.0
2	Татварын бус орлого	3,283,502.0	3,459,302.0	(175,800.0)
2.1	Нийтлэг татварын бус орлого	3,283,502.0	3,079,302.0	204,200.0
2.1.4	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	330,000.0	125,800.0	204,200.0

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2021 оны 1/2281 тоот албан бичгийн 1 дүгээр хавсралт

Аймгийн Татварын хэлтэс нь 2021 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар 2,509.5 сая төгрөгийн илүү төлөлт, 754.0 сая төгрөгийг дутуу төлөлттэйгөөс 369.2 сая төгрөг нь 2017 оноос хуримтлагдан үүссэн байна. Өмнөх оны орлогын албан татварын дутуу төлөлтийг барагдуулснаар 369.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх бүрэн боломжтой байна.

Дүрслэл 1 (2017 оноос хуримтлагдсан авлага)



Эх сурвалж: Орон нутгийн татварын гүйцэтгэлийн 2021 оны мэдээ

Сангийн яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу Газрын төлбөрийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу газрын төлбөр ногдуулах итгэлцүүрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн тогтоож, ногдуулалтыг шинэчлэн дахин хийгээгүй байна.

### ДҮГНЭЛТ:

Аймгийн 2021 оны орлогыг Сангийн яамнаас хянаж ирүүлсэн доод хязгаарыг баримтлан төлөвлөсөн хэдий ч ХХОАТ-ыг 1,000.0 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 204.2 сая төгрөгөөр тус тус буруулан төлөвлөсөн байна.

Өмнөх оны авлагын үлдэгдлийг бүрэн барагдуулснаар 369.2 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэх боломжтой байна.

### САНАЛ:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 1,573.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

### ҮР АШИГ САЙЖРУУЛАХ САНАЛ:

Газрын төлбөрийн тухай хуульд 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу газрын төлбөр ногдуулах итгэлцүүрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн тогтоож, ногдуулалтыг шинэчлэн дахин хийх.

### БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ

Аймгийн 2022 оны төсвийн төслийн суурь зарлагыг Сангийн яамнаас баталсан хязгаартай харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 4 (Сангийн яамны зарлагын хянасан хязгаар болон орон нутгийн төсвийн төслийн зарлагын харьцуулалт)

		/мянган төгрөг/		
д/д	Үзүүлэлт	Сангийн яамны хянасан төсөв	2022 оны аймгийн төсвийн төсөл	Сангийн яамны хянасан зөрүү
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА</b>		<b>52,125,449.8</b>	<b>60,401,036.3</b>	<b>8,275,586.5</b>
1	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	187,195.0	488,860.6	301,665.6
2	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	920,654.3	1,012,707.2	92,052.9
3	Аймгийн Засаг даргын Тамгын газар	1,223,422.8	2,832,264.2	1,608,841.4
4	Сумын Засаг даргын Тамгын газар	5,223,739.0	5,603,933.9	380,194.9
5	Ахмадын сан /аймгийн ОН Төсвийн байгууллага/		20,245.6	20,245.6
6	Санхүүгийн хяналт, аудитын алба	152,590.9	237,342.2	84,751.3
7	Орон нутгийн өмчийн газар	157,285.2	175,606.3	18,321.1
8	Насан туршийн боловсролын төв		25,920.0	25,920.0
<b>9</b>	<b>Аймгийн байгаль орчныг хамгаалах газар</b>	<b>1,962,380.9</b>	<b>2,100,733.9</b>	<b>138,353.0</b>
9.1	Үүнээс: Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	1,527,500.0	1,689,900.0	162,400.0
9.2	Байгал орчин аялал жуулчлалын газар	434,880.9	410,833.9	(24,047.0)
10	Ойн анги /Халхгол, Баян-Уул/	47,339.3	123,547.2	76,207.9
11	Соёл урлагийн байгууллагын ашиглалтын зардал	340,286.6	340,286.6	-
12	Биеийн тамир спортын байгууллагын ашиглалт үйлчилгээний зардал	70,007.2	70,007.2	-
13	Эрүүл мэндийн байгууллагын ашиглалт үйлчилгээний зардал	1,679,453.4	1,679,453.4	-
14	Боловсролын байгууллагын ашиглалт үйлчилгээний зардал	8,100,827.3	8,100,827.3	-
15	Төрийн болон орон нутгийн өмчийн барилгын үйлчилгээ ашиглалт /ОН-ОН/	863,495.9	863,495.9	-
16	Төрийн болон орон нутгийн өмчийн засвар, арчилгаа	772,941.4	772,941.4	-
<b>17</b>	<b>Хот тохижуулах газар</b>	<b>577,568.7</b>	<b>1,371,415.6</b>	<b>793,846.9</b>
17.1	Үүнээс: Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ	577,568.7	1,371,415.6	793,846.9
18	Аймгийн Засаг даргын нөөцийн сан	907,489.0	907,489.0	-
19	Аймгийн халамжийн сан	188,617.5	188,617.5	-
20	Мал хамгаалах сан	-	195,080.0	195,080.0
21	Авто замын сан	1,097,000.0	1,097,000.0	-
22	Аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сан	15,784,809.7	21,480,805.8	5,695,996.1
23	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардал	10,694,994.3	9,194,075.0	(1,500,919.3)
24	Засгийн газрын өрийн үйлчилгээ	53,502.0	53,502.0	-
<b>25</b>	<b>Аймгийн Засаг даргын Ерөнхий дансаас гарах зардал</b>	<b>1,119,849.4</b>	<b>1,464,878.5</b>	<b>345,029.1</b>
25.1	Хотын нийтийн хүн тээвэр	66,000.0	245,000.0	179,000.0
25.2	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	82,215.0	82,215.0	-
25.3	Мал эмнэлгийн үйлчилгээ	251,707.1	251,707.1	-
25.4	Усан хангамжийн татаас	64,000.0	64,000.0	-
25.5	Хот тохижилтын зардал	200,000.0	200,000.0	-
25.6	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	326,400.0	326,400.0	-
25.7	Агаарын бохирдлыг бууруулах	8,516.5	10,000.0	1,483.5
25.8	Дорнод аймгийн байгаль хамгаалалтын захиргаа	57,259.1	98,083.6	40,824.5
25.9	Аймгийн ахмадын хороо	33,429.5	33,429.5	-
25.10	Аймгийн ахмад настны амралт чөлөөт цагийн төв	30,322.2	30,322.2	-
<b>25.11</b>	<b>Хөтөлбөр, төслийн удирдлага зохицуулалт</b>	<b>-</b>	<b>123,721.1</b>	<b>123,721.1</b>
25.11.1	Үүнээс: Зүүн бүсийн зөвлөлийн зардал		15,000.0	15,000.0
25.11.2	Аялал жуулчлалын төсөл хөтөлбөрийн нэгжийн зардал		15,000.0	15,000.0
25.11.3	Дорнод аймгийн ЖДҮ-ийг дэмжих төв		93,721.1	93,721.1

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2021 оны 1/2281 тоот албан бичгийн 1 дүгээр хавсралт

“Аймгийн 2022 оны төсвийн төсөл”-д суурь зарлагыг Сангийн яамнаас баталсан дээд хязгаараас нийт 4.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн батлахаар төлөвлөсөн байна.

Сангийн яамны хянасан зардлын хязгаараас хэтрүүлэн зардлыг төлөвлөхөд нөлөөлсөн хүчин зүйлийг судлахад:

1. Хэрлэн сумын ИТХ болон ЗДТГ нь Сангийн яамнаас хянасан орон тооны хязгаараас хэтрүүлэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын тамгын газрын шинэ байр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж ашиглалтад орохтой холбоотой шаардагдах тавилга, эд хөрөнгөд 255.2 сая төгрөг төсөвлөсөн байна.
2. Аймаг болон сумдын Засаг даргын нөөц хөрөнгөд 1,287.0 сая төгрөгийг төсөвлөсөн бөгөөд дээрх зардал нь Сангийн яамны хянасан хязгаарт багтдаггүй байна.
3. Сангийн яамнаас зөвхөн Баян-Уул сумын ойн ангийн зардлыг хянасан. Харин шинээр байгуулагдаж буй Халхгол сумын ойн ангийн зардлыг нэмэгдүүлэн хянаагүй байна.
4. Сангийн яамны хянасан хязгаараас хотын нийтийн тээврийн үйлчилгээний зардлыг 179.0 сая төгрөг, Байгаль хамгаалалтын захиргааны зардлыг 42.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.
5. Төрийн аудитын байгууллагаас 2018-2021 оны төсвийн төслийн санал болон 2021 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн гүйцэтгэлийн тайланд тус тус орон тооны хязгаарыг нэмэгдүүлэх тухай саналыг Сангийн яаманд хүргүүлэх зөвлөмж өгсний дагуу аймгийн Засаг дарга хүргүүлсэн боловч одоог хүртэл хариу ирээгүй байна.

## ДҮГНЭЛТ:

Хэрлэн сумын ИТХ-4, ЗДТГ-17 орон тоо илүү ажиллаж байна.

Төсвийн суурь зарлагыг Сангийн яамны баталсан хязгаараас 4.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3-т заасантай нийцэхгүй байна.

## БҮЛЭГ 4. ТӨС-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, ЗОРИЛТОТ ТҮВШИН

### 4.1. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Аймгийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлтийг Төсвийн тухай хууль, төсвийн төсөл бэлтгэх удирдамж, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журам болон бусад холбогдох журам, зааварт нийцсэн эсэхийг шалгуур болгон авч үзлээ.

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын төсвийг 2022 онд нийт 5,526.1 сая төгрөг байхаар төлөвлөж, 175.0 сая төгрөгийг өмнөх оны 5 төсөл, арга хэмжээнд зарцуулахаар шилжүүлж, шинээр хэрэгжүүлэх 35 төсөл арга хэмжээнд 5,351.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд хууль, бодлогын баримт бичгийн шаардлагад нийцэхгүй дараах асуудлууд байна. Үүнд:

1. Аймгийн орон нутгийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан дараах 2 төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдахгүй байна. Үүнд:

- "Иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний танхим"-д компьютер, тоног төхөөрөмж /Татварын хэлтэс/ -20.0 сая төгрөг,
- Компьютер, тоног төхөөрөмж /Санхүүгийн хяналт, аудитын алба/ -19.5 сая төгрөг.

2. Орон нутгийн төсвөөр улсын төсөвт байгууллагуудын автомашин худалдан авах болон засвар, тоног төхөөрөмж авах ажилд 116.6 сая төгрөгийг төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6 дахь “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн зарчимд нийцэхгүй байна.

- Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл /Сууц өмчлөгчдийн холбооны Дорнод аймаг дахь зөвлөл /96.6 сая төгрөг,
- "Иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний танхим"-д компьютер, тоног төхөөрөмж /Татварын хэлтэс/ -20.0 сая төгрөг.

3. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дахь “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэсэн заалттай нийцэхгүй зураг, төсөвгүй 2 төсөл, арга хэмжээ байна.

- Сэвсүүлийн голын гүүр, хоолой /Дашбалбар сум/ -280.0 сая төгрөг
- Мөсөн гулгуурын талбай байгуулах /Биеийн тамир, спортын газар/-10.0 сая төгрөг

4. Төсвийн тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, бусад холбогдох хуульд заасан аймгийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд тусгагдаагүй 1,097.6 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ байна.

- Сумдын Цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн эргүүлийн автомашин -125.0 сая төгрөг
- Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан орон сууцны барилгын хөрөнгө оруулалтын 50 хувь /Гурванзагал сум/ -703.0 сая төгрөг
- Нисэх онгоцны буудлын зам талбай, цахилгаан эрчим хүч, барилга, тохижилт /Баяндун, Халхгол сум/ -269.6 сая төгрөг

## ДҮГНЭЛТ:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль зөрчин үндэслэлгүй, тухайн шатны төсөвт хамаарахгүй, бодлогын баримт бичигт тусгагдаагүй, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

## САНАЛ:

Төсвийн зарлагыг бууруулах нийт 1,504.2 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- "Иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний танхим"-д компьютер, тоног төхөөрөмж /Татварын хэлтэс/ -20.0 сая төгрөг,
- Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл /Сууц өмчлөгчдийн холбооны Дорнод аймаг дахь зөвлөл /96.6 сая төгрөг,
- Сэвсүүлийн голын гүүр, хоолой /Дашбалбар сум/ -280.0 сая төгрөг,
- Мөсөн гулгуурын талбай байгуулах /Биеийн тамир, спортын газар/-10.0 сая төгрөг
- Сумдын Цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн эргүүлийн автомашин -125.0 сая төгрөг
- Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан орон сууцны барилгын хөрөнгө оруулалтын 50 хувь /Гурванзагал сум/ -703.0 сая төгрөг
- Нисэх онгоцны буудлын зам талбай, цахилгаан эрчим хүч, барилга, тохижилт /Баяндун, Халхгол сум/ -269.6 сая төгрөг

Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх нийт 19.5 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ байна.

- Компьютер, тоног төхөөрөмж /Санхүүгийн хяналт, аудитын алба/ -19.5 сая төгрөг.

## 4.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БУС ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын бус шинжтэй төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд санал, дүгнэлт өгөхдөө Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль журам, Сангийн яамны 2022 оны төсвийн төслийг боловсруулахад баримтлах чиглэл, удирдамжийг шалгуур болгон авч үзлээ.

Орон нутгийн 2022 оны төсвийн төслийн хөрөнгө оруулалтын бус шинжтэй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтаас Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журам, Сангийн яамны 2022 оны төсвийн төслийг боловсруулахад баримтлах чиглэл, удирдамжид нийцээгүй, төсвийн тооцоо нь зөрүүтэй, хөрөнгө оруулалтын шинжтэй 497.6 сая төгрөгийн 13 арга хэмжээг **хасах санал** оруулж байна.

Хүснэгт 5 (Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журамд нийцээгүй төсөл, хөтөлбөрийн жагсаалт)

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Санхүүжих дүн
2.5.7	Аймгийн баяр наадмын зардал	80,000.0
2.5.9	Хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, ашиглалтын явц, чанарт хяналт үнэлгээ хийх	10,000.0
2.5.16	Цэргийн албан хаагч болон дүйцүүлэх, бэлтгэл үүрэгтнүүдийн сургалтын танхимын камержуулалд	8,500.0
2.5.20	Гамшигт тэсвэртэй орон нутаг төслийн хүрээнд хүүхэд багачуудад гамшигийн эрсдэлийн талаар мэдлэг олгох "Аврагч мазаалай" сургалтын танхим байгуулахад орон нутгаас хариуцах зардал	9,500.0
2.5.21	Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд хөтөлбөрийн хүрээнд "Элэгний В вирусийн халдваргүй нярай", "Эрүүл эмэгтэй", "Эхчүүдээ хайрлая" төслийг үргэлжлүүлэх	50,000.0
2.5.27	БЗДХ болон Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах төсөл	60,000.0
2.5.28	Зорилтот бүлгийн хүүхдүүдийг томуугийн вакцинд хамруулж, дархлаажуулалт	67,500.0
2.5.29	"Эрүүл оюутан" төсөл	20,000.0
2.5.30	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд алслагдсан багуудад эмийн сан ажиллуулах /Хэрлэн сум/	13,200.0
2.5.32	Халдварт бус өвчинтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд "Эрүүл мэндийг дэмжигч байгууллага" шалгаруулах, "Зүрх судасны өвчнөөс сэргийлэх Монпен санаачилга", Харшлаас сэргийлэх арга хэмжээ	58,100.0
2.5.34	"Сургууль, цэцэрлэгийн эмч ба-Эрүүл мэнд" төсөл	54,800.0
2.5.37	Аймгийн болон боловсролын салбарын зорилтот жилийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний зардал	10,000.0
2.5.44	Нийгмийн цогц явуулын үйлчилгээ /эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, соёл, ахуй үйлчилгээ/	56,000.0
<b>Нийт дүн</b>		<b>497,600,0</b>

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2021 оны 1/2281 тоот албан бичгийн 2 дугаар хавсралт

### ДҮГНЭЛТ:

Орон нутгийн 2022 оны төсвийн төсөлд тусгасан нийт 75 төсөл, хөтөлбөр, арга хэмжээний 32 буюу 42.6 хувь нь урсгал зардлын шинжтэй байна.

### САНАЛ:

Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журам, Сангийн яамны 2022 оны төсвийн төслийг боловсруулахад баримтлах чиглэл, удирдамжид нийцээгүй, төсвийн тооцоо нь зөрүүтэй, хөрөнгө оруулалтын шинжтэй 497.6 сая төгрөгийн 13 арга хэмжээг орон нутгийн 2022 оны төсвийн төслийн хөрөнгө оруулалтын бус шинжтэй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтаас **хасах санал** оруулж байна.

### ЗӨВЛӨМЖ:

Хөрөнгө оруулалтын бус төсөл, хөтөлбөр, арга хэмжээний үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц хөтөлбөр болгон багцалж, боловсруулан батлуулж байх.

#### 4.3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Аймгийн ОНХС-ийн Төсвийн төсөлд санал, дүгнэлт өгөхдөө Төсвийн тухай хуулийн 58, 59, 60 дугаар зүйл, Сангийн Сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-ийн үйл ажиллагааны журам, Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам, Сангийн яамны 2022 оны төсвийн төсөл боловсруулах удирдамжийг шалгуур болгон авч үзлээ.

ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 11.0 тэрбум төгрөгийн 68 төсөл арга хэмжээнд хийсэн дүн шинжилгээ.

ОНХС-ийн төсвийн төсөлд хууль, журмын шаардлагад нийцэхгүй дараах асуудлууд байна.

1. Батлагдсан зураг төсөвгүй 38.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээ байна.

- Монгол дайчдын хөшөөг засварлах /Хэрлэн сум, 3 дугаар баг/ - 38.0 сая төгрөг.

2. Батлагдсан зураг, төсвөөс зөрүүтэй төлөвлөсөн, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх хугацааг бодитой тооцоогүй, төсвийн үр ашгийг сайжруулах шаардлагатай нийт 370.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ байна.

Хүснэгт 6 (Үр ашгийг сайжруулах төсөл, арга хэмжээ)

/мянган төгрөг/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	Зураг төсвийн мөнгөн дүн
		Эхлэх	Дуусах			
2.1.1	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Баяндун сум/	2022	2022	120,000.0	120,000.0	602,627.9
2.1.2	Эхийн амрах байрны барилгын дулааны шугам сүлжээний засвар /Хөлөнбуйр сум/	2022	2022	30,000.0	30,000.0	23,517.8
2.1.3	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Чойбалсан сум/	2022	2022	120,000.0	120,000.0	264,756.5
2.3.5	"Цахим анги" төсөл	2022	2022	100,000.0	100,000.0	252,630.0
<b>Нийт дүн</b>				<b>370,000.0</b>	<b>370,000.0</b>	<b>1,143,532.2</b>

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2021 оны 1/2281 тоот албан бичгийн 4 дүгээр хавсралт

3. Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгаагүй дараах төсөл арга хэмжээ байна.

Хүснэгт 7 (Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д заасан төсөвлөлтийн шалгуурт нийцээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт)

/мянган төгрөг/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	Хувь хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа
		Эхлэх	Дуусах				
2.2.2	Эхийн амрах байрны барилга /Булган сум/	2022	2023	291,200.0	50,000.0	50 хувиас бага	2
2.2.13	Читийн гудамжны ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээг шилжүүлэх	2022	2023	325,780.0	108,871.7	50 хувиас бага	2

	/Хэрлэн сумын 6 дугаар баг/						
2.2.15	Хэрлэн сумын 405, 406 дугаар байранд боловсон ариун цэврийн байгууламж /Хэрлэн сум 11 дүгээр баг/	2022	2023	116,408.9	56,408.9	50 хувиас бага	2
2.2.22	Хүүхэд, эмэгтэйчүүдийн гудамжны авто замаас Мянгат хорооллын ар талаар явган зам, гэрэлтүүлэг бүхий авто зам /Хэрлэн сум, 7 дугаар баг/	2022	2024	1,425,364.4	300,000.0	33 хувиас бага	3
2.2.24	Содномдаржаагийн гудамжнаас Хивс Ялалт хорооллын дундах босоо тэнхлэгийн автозамыг үргэлжлүүлэх /Хэрлэн сум 10, 11 дүгээр баг/	2022	2023	630,664.8	200,000.0	50 хувиас бага	2
2.2.27	Манлайбаатар Дамдинсүрэнгийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн байгуулах /Хэрлэн сум, 1 дүгээр баг/	2022	2023	344,128.8	144,128.8	50 хувиас бага	2
<b>Нийт дүн</b>				<b>3,133,546.9</b>	<b>859,409.4</b>		

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2021 оны 1/2281 тоот албан бичгийн 4 дүгээр хавсралт

### САНАЛ:

Зураг төсөвгүй 38.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг **хасах санал** оруулж байна.

- Монгол дайчдын хөшөөг засварлах /Хэрлэн сум, 3 дугаар баг/ - 38.0 сая төгрөг.

Төсвийн санхүүжилтийн **үр ашгийг дээшлүүлэх** нийт 1,229.4 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээний саналыг оруулж байна.

Хүснэгт 8 (Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх)

/мянган төгрөг/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
2.2.2	Эхийн амрах байрны барилга /Булган сум/	2022	2023	291,200.0	50,000.0
2.2.13	Читийн гудамжны ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээг шилжүүлэх /Хэрлэн сумын 6 дугаар баг/	2022	2023	325,780.0	108,871.7
2.2.15	Хэрлэн сумын 405, 406 дугаар байранд боловсон ариун цэврийн байгууламж /Хэрлэн сум 11 дүгээр баг/	2022	2023	116,408.9	56,408.9
2.2.22	Хүүхэд, эмэгтэйчүүдийн гудамжны авто замаас Мянгат хорооллын ар талаар явган зам, гэрэлтүүлэг бүхий авто зам /Хэрлэн сум, 7 дугаар баг/	2022	2024	1,425,364.4	300,000.0

2.2.24	Содномдаржаагийн гудамжнаас Хивс Ялалт хорооллын дундах босоо тэнхлэгийн автозамыг үргэлжлүүлэх /Хэрлэн сум 10, 11 дүгээр баг/	2022	2023	630,664.8	200,000.0
2.2.27	Манлайбаатар Дамдинсүрэнгийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн байгуулах /Хэрлэн сум, 1 дүгээр баг/	2022	2023	344,128.8	144,128.8
2.1.1	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Баяндун сум/	2022	2022	120,000.0	120,000.0
2.1.2	Эхийн амрах байрны барилгын дулааны шугам сүлжээний засвар /Хөлөнбуйр сум/	2022	2022	30,000.0	30,000.0
2.1.3	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Чойбалсан сум/	2022	2022	120,000.0	120,000.0
2.3.5	"Цахим анги" төсөл	2022	2022	100,000.0	100,000.0
<b>Нийт дүн</b>				<b>3,503,546.9</b>	<b>1,229,409.4</b>

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2021 оны 1/2281 тоот албан бичгийн 4 дүгээр хавсралт

## БҮЛЭГ 5. САНГИЙН ЗАРДЛУУД

### 5.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ЗАРДАЛ

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын орлогыг бүрдүүлэхдээ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу энэ хуулийн 13.2<sup>1</sup>-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

Хүснэгт 9 (Хуулиар зөвшөөрсөн зарцуулах хувь, хэмжээ)

Д/д	Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төрөл	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаар /нийт орлогын дүнгээс хувиар/
1	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	15 хувь
2	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	50 хувь
3	Газрын нөөцийн төлбөрийн орлого	15 хувь
4	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	85 хувь
5	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	35 хувь

Эх сурвалж: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд зааснаар БОХНСЗ-д зарцуулах хувь хэмжээг 1,452.5 сая төгрөг байхаар заасан боловч аймгийн 2022 оны төсвийн төсөлд 1,689.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 10 (Хуулиар зарцуулах хувь, хэмжээг төсвийн төсөлтэй харьцуулсан харьцаа)

/мянган төгрөг/

Д/д	Зардлын ангилал	Сангийн яамнаас хянасан	Хуулиар зарцуулах		Төсвийн төсөлд	Зөрүү
			хувь	хэмжээ		
<b>Төрөл</b>						
1	Байгалийн ургамал	0	15%	0	0	0

<sup>1</sup> 13.2. Төлбөрийн орлогын хэсгийг дор дурдсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдүүлнэ:

13.2.1. байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого;  
13.2.2. ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого;  
13.2.3. ойн нөөц ашигласны төлбөрийн орлого;  
13.2.4. ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого;  
13.2.5. газрын нөөцийн төлбөрийн орлого.


2	Ус рашаан	4,000,000.0	35%	1,400,000.0	521,000.0	-879,000.0
3	Ан амьтан	20,000.0	50%	10,000.0	10,000.0	0
4	Ойн нөөц	50,000.0	85%	42,500.0	555,500.0	+513,000.0
<b>Бусад</b>						
5	Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдолыг бууруулах	0	0	0	130,000.0	+130,000.0
6	Хог хаягдлын менежментийг сайжруулж хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд	0	0	0	311,000.0	+311,000.0
7	Шилжих хөрөнгө	0	0	0	162,400.0	+162,400.0
<b>Нийт дүн</b>		<b>4,070,000.0</b>	<b>0</b>	<b>1,452,500.0</b>	<b>1,689,900.0</b>	<b>+237,400.0</b>

Эх сурвалж: Аймгийн 2022 оны төсвийн төсөл, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт

Зарлагын төлөвлөлтийг өмнөх онтой харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 2 (БОХНС чиглэлээр зарцуулах төсвийн харьцуулалт)

/мянган төгрөг/



Эх сурвалж: Орон нутгийн 2021, 2022 оны төсвийн төсөл

БОХНС чиглэлээр 2022 онд зарцуулах төсөв хуулиар зарцуулах хэмжээнээс 234.4 сая төгрөгөөр буюу 16.1 хувиар өссөн байна.

Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоол “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 1.2-т “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна.” гэж заасан байна.

Гэтэл хог хаягдлын менежмент, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдолыг бууруулах, өмнөх оноос шилжиж ирсэн төсөл, арга хэмжээнд нэмж зарцуулахаар төлөвлөж, Сангийн яамнаас хянасан төсвөөс 237.4 сая төгрөгөөр илүү зарцуулахаар төлөвлөсөн байна. /Аймгийн СТСХ-ээс өгсөн тайлбар: БОАЖЯ-наас улсын хэмжээнд байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн нийт орлогыг аймгуудад тэгш байдлаар хуваарилсантай холбоотой байна./

## ДҮГНЭЛТ:

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг 2022 онд нийт 34 төсөл, арга хэмжээнд 1,689.9 сая төгрөг байхаар төлөвлөж, 162.4 сая төгрөгийг өмнөх оны 5 төсөл, арга хэмжээнд зарцуулахаар шилжүүлж, шинээр хэрэгжүүлэх 29 төсөл, арга хэмжээнд 1,527.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Үүнээс 805.1 сая төгрөгийн өртөгтэй 11 төсөл, арга хэмжээ нь зураг, төсөв, тооцоо, судалгаагүй, төсөв зөрүүтэй, 215.9 сая төгрөгийн өртөгтэй 5 төсөл, арга хэмжээний төсвийн задаргаа, тооцоолол дутуу хийгдсэн байна.

Бусад 669.0 сая төгрөгийн өртөгтэй 18 төсөл, арга хэмжээний зураг төсөв, тооцоо, судалгаа, ажлын даалгавар иж бүрэн байна.

Дүрслэл 3 (БОХНСЗ-аар хийгдэх төсөл, арга хэмжээний хууль, журмын шаардлага хангасан эсэх талаарх харьцуулалт)

**2021 оны төсвийн төсөл**



**2022 оны төсвийн төсөл**



Эх сурвалж: Орон нутгийн 2021, 2022 оны төсвийн төсөл

**Сайн тал:**

1. Өмнөх оны төсвийн төсөлд өгсөн саналын дагуу байгаль орчныг нөхөн сэргээх төсөл, арга хэмжээний төсвийг БОАЖГ-т шилжүүлж, хуваарилж, баталсан байна.
2. Төсвийн шаардлагыг хангасан байдлыг нийт ТАХ-нд харьцуулж үзэхэд ажлын зураг, төсөв, даалгавар, төлөвлөгөөний иж бүрэн байдал өмнөх оноос 44 хувиар өссөн, зураг, төсөв, даалгавар төлөвлөгөө бүрэн бус байдал 24 хувиар, ажлын төсөв, тооцоолол, даалгавар, удирдамж, төлөвлөгөө хийгдээгүй байдал 20 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байгаа нь ажлын зохион байгуулалт сайжирч, Төрийн аудитын байгууллагаас өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласантай холбоотой байна.

**САНАЛ:**

Төсвийн шаардлага хангаагүй 2.1.1, 2.1.4, 2.1.5, 2.2.6, 2.3.2, 2.4.2-2.4.5 дахь ажлыг бүхэлд нь буюу 401.0 сая төгрөг, зураг, төсөв, төсвийн задаргаа зөрүүтэй хийгдсэн 2.2.4, 2.3.8 дахь ажлуудын төсвийн зарим хэсгийг буюу 17.9 сая төгрөг, нийт 805.1 сая төгрөгийн өртөгтэй 11 ажлаас **418.9** сая төгрөгийг төсвөөс **хасах саналыг** гаргаж байна.

Хүснэгт 11 (Жагсаалтаас хасах саналтай төсөл, арга хэмжээний жагсаалт)

/мянган төгрөг/

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөвт өртөг	Үүнээс хасах	Тайлбар
1	2.1.1. "Нөхөн сэргээлт-2024 хүртэл эрчимжүүлэх" нэгдсэн арга хэмжээний зардал	5,000.0	5,000.0	Төсвийн тооцоолол дутуу, үйл ажиллагааны зардлын задаргаа байхгүй, БОАЖГ-ын үйл ажиллагаанд тавигдах зардал. /Бүхэлд нь хасах/
2	2.1.4. "Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт"-д хяналт тавих, гүйцэтгэлийг дүгнэх ажлын зардал	5,000.0	5,000.0	Төсвийн тооцоолол дутуу, үйл ажиллагааны зардлын задаргаа байхгүй, БОАЖГ-ын үйл ажиллагаанд тавигдах зардал. /Бүхэлд нь хасах/
3	2.1.5. "Улсын тусгай хамгаалалттай байгалийн нөөц газруудыг хамгаалах"	20,000.0	20,000.0	Газрын нөөцийн төлбөрийн орлого байхгүй, Дорнод аймгийн Байгаль хамгаалалтын захиргааны үйл

	менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардал			ажиллагаанд тавигдах зардал. /Бүхэлд нь хасах/
4	2.2.4. Ус цэнгэгжүүлэх төхөөрөмж бүхий ундны усны худаг гаргах /Матад, Гурванзагал, Халхгол, Чойбалсан сумд/	388,000.0	17,000.0	Зураг, төсвийн дүн 371,000.0 мянга, зөрүү 17,000.0 мянган төгрөгийг төсөвт өртгөөс хэсэгчлэн хасах.
5	2.2.6. Булгийн эхийг хашиж хамгаалах ажил (Цагаа-Овоо сум)	20,000.0	20,000.0	Зураг, төсөв байхгүй. /Бүхэлд нь хасах/
6	2.3.2. Иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгжийн мод тарих хөдөлгөөнийг сайн дурын хэлбэрээр өрнүүлэн, урамшуулах	120,000.0	120,000.0	Засгийн газрын 43-р тогтоолд ойн мэргэжлийн анги, нөхөрлөлд дэмжлэг үзүүлэх тухай заалттай боловч аймгийн төвд мод тарих хөдөлгөөнд урамшуулал олгох заалт байхгүй, журмын зорилготой бүрэн нийцээгүй байна. Урамшуулал олгох нь хууль, журамд нийцэхгүй байна. /Бүхэлд нь хасах/
7	2.3.8. Тал хээрийн түймэрт өртөж болзошгүй бүсэд цурам татах	16,050.0	923.7	Төсвийн задаргаа 15,126.3 мянган төгрөгөөр хийгдсэн, зөрүү 923.7 мянган төгрөгийг төсөвт өртгөөс хэсэгчлэн хасах.
8	2.4.2. Хуучин хогны цэгийг дарж булшлан, биологийн нөхөн сэргээлт хийх	80,000.0	80,000.0	Техникийн тодорхойлолт хийгдсэн боловч, ажлын даалгавар хийгдээгүй. Бусад байгууллагын чиг үүрэгт хамаарна. /Бүхэлд нь хасах/
9	2.4.3. Шинээр байгуулах хогны цэгийг хашаажуулах ажлыг үе шаттайгаар хийж дуусгах	140,000.0	140,000.0	Бусад байгууллагын чиг үүрэгт хамаарна. /Бүхэлд нь хасах/
10	2.4.4. Бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулах ажлын зардал /Хэрлэн голын дагуу/	3,000.0	3,000.0	Бусад байгууллагын /Хэрлэн сумын ЗДТГ, Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ гэх мэт/ чиг үүрэгт хамаарна. /Бүхэлд нь хасах/
11	2.4.5. Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор нэгдсэн хяналт шалгалт зохион байгуулна	8,000.0	8,000.0	Төсвийн задаргаа 3,000.0 мянган төгрөгөөр хийгдсэн. БОАЖГ-ын үйл ажиллагаанд тавигдах зардал. /Бүхэлд нь хасах/
<b>Нийт дүн</b>		<b>805,050.0</b>	<b>418,923.7</b>	

Эх сурвалж: Аймгийн 2022 оны төсвийн төслийн 6 дугаар хавсралт

Ажлын төсөв, төлөвлөгөө, даалгавар, техникийн тодорхойлолтыг батлуулаагүй, төсвийн тооцооллын задаргаа нь бүрэн хийгдээгүй зэрэг иж бүрэн байдлыг хангаагүй 215.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээний **үр дүнг сайжруулах** саналыг гаргаж байна. Үүнд:

Хүснэгт 12 (Төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн шаардлага хангасан эсэх талаарх шинжилгээ)  
/мянган төгрөг/

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөвт өртөг	Төсвийн төлөвлөлтийн шаардлагыг хангасан эсэх
1	1.3. Чойбалсан хот орчмын эвдэрсэн газруудад нөхөн сэргээлт хийх	36,000.0	Ажлын даалгавар хийгдсэн боловч төсвийн задаргаа, тооцоолол хийгдээгүй.
2	1.4. Рашаан, булаг, шандын эхийг хашиж хамгаалах зардал	46,000.0	Ажлын даалгавар, зураг, төсөв, нэршил зөрүүтэй хийгдсэн.
3	2.2.5. Сумын ногоон байгууламжийн усалгаанд ашиглах гүний худаг гаргах зардал	60,000.0	Зардлын тооцооны эх сурвалж байхгүй, холбогдох албан тушаалтнаар хянуулж, батлуулаагүй. Техникийн


			тодорхойлолт хийгдсэн.
4	2.3.6. Ойн хортон, хөнөөлт шавжтай тэмцэх ажлын зардал /Баян-Уул, Халхгол сумд/	43,900.0	Ажлын даалгавар баталсан ч зардлын задаргаа, тооцоо, судалгаа хийгдээгүй.
5	2.4.1. “Иргэдийн экологийн боловсрол, хүмүүжил, нөлөөллийн ажил”-ыг зохион байгуулах, хогийг эх үүсвэрт нь ангилан ялгах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	30,000.0	Техникийн тодорхойлолт батлагдаагүй, төсвийн задаргаа байхгүй.
<b>Нийт дүн</b>		<b>215,900.0</b>	

Эх сурвалж: Аймгийн 2022 оны төсвийн төслийн 6 дугаар хавсралт

## 5.2. АВТО ЗАМЫН САН

Дорнод аймагт замын сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд нийт 9 төсөл, арга хэмжээнд 1,097.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Дүрслэл 4 (Төсөл, арга хэмжээний тоо болон санхүүжилтийн харьцуулсан шинжилгээ)



Эх сурвалж: Орон нутгийн 2021, 2022 оны төсвийн төсөл

Өмнөх онтой харьцуулахад төсөл, арга хэмжээ 1-ээр, санхүүжилт 764.0 сая төгрөгөөр буюу 3.3 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоол “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3-т заасны дагуу “Гэнэтийн хүчин зүйл буюу байгалийн гамшигт үзэгдэл, осол болсны улмаас авто зам, замын байгууламжид эвдрэл, гэмтэл үүссэний улмаас авто замын хөдөлгөөн хэвийн үргэлжлэх боломжгүй болсон тохиолдолд сэргээн засварлахад шаардагдах зардлыг авто замын сангийн тухайн жилийн төсвөөс тэргүүн ээлжинд санхүүжүүлнэ.” 3.5-д “Авто замын сангийн тухайн жилийн төсвийг төлөвлөх, хуваарилахад дараах зарчмыг баримтална: 3.5.1. төсвийн 90-ээс багагүй хувийг Авто замын тухай хуулийн 24.3, 24.4-т тус тус заасан үйл ажиллагаанд; 3.5.2. төсвийн 10 хүртэлх хувийг Авто замын тухай хуулийн 24.5-д заасан үйл ажиллагаанд” гэж зааснаар 93.6 хувийг авто замын арчлалт, засварын ажил, гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засварын ажилд, 6.4 хувийг авто замын засвар, арчлалтын ажлыг хариуцсан байгууллагын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн нь тус хуулийн зүйл, заалттай нийцэж байна.

### ДҮГНЭЛТ:

Авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний жагсаалтын 1.7 дахь 100.0 сая төгрөгийн өртөгтэй “Авто замын дагуу орц, гарц гаргаж засварлах” арга хэмжээнд зураг, төсөв хийгдээгүй байна.

Мөн жагсаалтын 1.2 дахь 100.0 сая төгрөгийн өртөгтэй “Цемент бетон хатуу хучилттай авто замын засвар /Хэрлэн сум/” арга хэмжээний төсөв нь төсөвт өртгөөс 0.8 сая төгрөгөөр, 1.4 дэх 150.0 сая төгрөгийн өртөгтэй “Хамар давааны засвар /Халхгол сум/” арга хэмжээний төсөв нь төсөвт өртгөөс 199.9 сая төгрөгөөр тус тус илүү хийгдсэн байна.

Хүснэгт 13 (Зураг, төсвийн харьцуулсан шинжилгээ)

/мянган төгрөг/

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөвт өртөг	Зураг, төсвийн үнэ	Үүнээс хасах, сайжруулах	Тайлбар
<b>Хасах</b>					
1	1.7. Авто замын дагуу орц, гарц гаргаж засварлах	100,000.0	0	100,000	Зураг, төсөв байхгүй учир бүхэлд нь хасах.
<b>Сайжруулах</b>					
2	1.2. Цемент бетон хатуу хучилттай авто замын засвар /Хэрлэн сум/	100,000.0	100,774.8	774.8	Зураг, төсвийн дүн 100,774.8 мянган төгрөг, зөрүү 774.8 мянган төгрөг.
3	1.4. Хамар давааны засвар /Халхгол сум/	150,000	349,891.6	199,891.6	Зураг, төсвийн дүн 349,891.6 мянган төгрөг, зөрүү 199,891.6 мянган төгрөг.
<b>Нийт дүн</b>		<b>350,000.0</b>			

Эх сурвалж: Аймгийн 2022 оны төсвийн төслийн 3 дугаар хэвсрэлт

## САНАЛ:

### Хасах:

1.7 дахь 100.0 сая төгрөгийн өртөгтэй “Авто замын дагуу орц, гарц гаргаж засварлах” арга хэмжээг нийт жагсаалтаас ХАСАХ саналтай байна.

### Сайжруулах:

Зураг төсвийн дүн, төсөвт өртөг зөрүүтэй хийгдсэн 1.2 дахь 100.0 сая төгрөгийн өртөгтэй “Цемент бетон хатуу хучилттай авто замын засвар /Хэрлэн сум/” арга хэмжээ,

1.4 дэх 150.0 сая төгрөгийн өртөгтэй “Хамар давааны засвар /Халхгол сум/” арга хэмжээг жагсаалтад зураг, төсвийн дүнгээр тусгаж, төсөвт сайжруулалт хийх шаардлагатай байна.

## 5.3. ХАЛАМЖИЙН САН

Халамжийн сангийн төсөв 2018 оноос улсын төсөвт шилжихдээ орон нутгийн шинж чанартай гэж үзэж Нийгмийн халамжийн тухай хуулийн 7.1<sup>2</sup> дэх заалтын 7.1.1<sup>3</sup> -дахь заалтын хүрээнд онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг орон нутгийн төсвөөс санхүүждэг хэвээр үлдээсэн байна.

Аймгийн 2022 оны төсвийн төсөлд 188.6 сая төгрөгөөр тусгасан нь өнгөрсөн оны батлагдсан төсвөөс 6.0 сая төгрөгөөр илүү төлөвлөжээ.

1. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5<sup>4</sup>-д дурдагдсан иргэнд олгодог байна. Энэхүү тэтгэмжийг 2020 онд 132.8 сая төгрөг батлагдаж 83 иргэнд зарцуулж

<sup>2</sup>“Халамжийн сангийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ”

<sup>3</sup> “улс, орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө”

<sup>4</sup> Онцгой тохиолдол

13.5.1. гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх;

13.5.2. 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн;

13.5.3. хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;

13.5.4. нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, дөрөв ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг, эх;

37.4 мянган төгрөгийн үлдэгдлийг Төрийн аудитын байгууллагаас өгсөн саналын дагуу орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Дорнод аймгийн 2021 оны төсөвт 132.0 сая төгрөг батлагдаж 11 сарын 27-ны өдрийн байдлаар 66.2 сая төгрөгийг 55 иргэнд зарцуулж, хүлээгдэж буй гүйцэтгэлээрээ 65.8 сая төгрөг байна. Тайлант он дуусахад ганцхан сарын хугацаа үлдээд байхад нийт батлагдсан санхүүжилтийн 50.0 хувийн үлдэгдэлтэй байна.

Халамжийн санд сар бүрийн тогтмол санхүүжилт болох 11.0 сая төгрөгөөр 12 дугаар сарын санхүүжилт, зарцуулалтыг тооцоход дансны үлдэгдэл болох 59.8 сая төгрөгийн хэмнэлт үүсэж аймгийн 2022 оны төсөвт орлого нэмэгдүүлэхээр байна.

2. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.2<sup>5</sup>-т дурдагдсан иргэд хамрагдах боломжтой байна. Уг үйлчилгээг 2020 онд 372 иргэнийг хамруулахаар 50.3 сая төгрөг батлагдсанаас 371 иргэн хамруулж 50.3 сая төгрөгийг бүрэн зарцуулсан байна. Харин 2021 онд 410 иргэн хамруулахаар төлөвлөснөөс одоогийн байдлаар /2021.11.27/ 246 иргэн хамруулж 45.6 сая төгрөгийг буюу батлагдсан төсвийн 90.1 хувийг зарцуулаад байна.

Халамжийн сангийн батлагдсан төсөв нь өмнөх онуудад гүйцэтгэлээрээ хэмнэлттэй гарч байсан байна. Энэ нь зорилтот хэрэглэгчдээс илүү төсөв баталж байсныг харуулж байна.

Дүрслэл 5 (Батлагдсан төсвийг гүйцэтгэлтэй харьцуулсан байдал)



Эх сурвалж: Орон нутгийн 2021, 2022 оны төсвийн төсөл

## ДҮГНЭЛТ:

Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд батлагдсан төсвөөс 59.8 сая төгрөгийн бодит хэмнэлт үүсэж байна. Үүнээс харахад 2022 онд төсөв хэмнэлттэй байх зарчмыг мөрдөж ажиллаагүй байна.

<sup>5</sup> Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ

- 18.2.1.ахмад настан;
- 18.2.2.хөгжлийн бэрхшээлтэй иргэн;
- 18.2.3.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд
- 18.2.4.хүчирхийлэлд өртсөн иргэн;
- 18.2.5.хорих ангиас суллагдсан иргэн;
- 18.2.6.согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн;
- 18.2.7.эдгэшгүй хүнд өвчтэй хүн;
- 18.2.8.гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн;
- 18.2.9.шилжин суурьшсан энэ хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн-иргэн, иргэн;
- 18.2.10.өрх толгойлсон эх /эцэг/.
- 18.2.11.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх.
- 18.2.12.гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн хүүхэд.

## САНАЛ:

Орон нутгийн 2022 оны төсвийн орлогыг халамжийн сангийн үлдэгдэл 59.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Дорнод аймгийн 2022 оны төсвийн төсөлд тусгасан 188.6 сая төгрөгийг бууруулж энэ оны гүйцэтгэлээр тусгах. Төсвөө багасгахгүй ирүүлж байгаа нь ЗГ-ын Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдахгүй байна.

## ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ:

1. Аймгийн төсвийн орлогыг Сангийн яамнаас хянасан хязгаарын дагуу батлах.
2. Газрын төлбөрийн тухай хуульд 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу газрын төлбөр ногдуулах итгэлцүүрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн тогтоож, ногдуулалтыг шинэчлэн дахин хийх.
3. Төсвийн суурь зарлагыг Сангийн яамны баталсан хязгаараас нэмэгдүүлэн төлөвлөхгүй байх.
4. Аймгийн ОНХС, хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө бодлогын баримт бичигт тусгагдсан, нийгмийн нэн тэргүүний ач холбогдлоор нь эрэмбэлсэн, тооцоо судалгаанд үндэслэгдсэн, хууль, журамд нийцсэн төсөл, арга хэмжээг төлөвлөж байх.
5. Орон нутгийн төсвийн хөрөнгийг тухайн шатны төсөвт хамаарахгүй арга хэмжээнд зарцуулахгүй байх.
6. Хөрөнгө оруулалтын бус хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхдөө тооцоо судалгаанд үндэслэгдсэн, хууль, журамд нийцсэн төсөл, арга хэмжээг төлөвлөж байх.
7. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг төлөвлөхдөө зураг, төсөв, тооцоо, судалгаанд үндэслэж төлөвлөж байх.
8. Халамжийн сангийн зарлагыг батлахдаа Засгийн газрын халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулж батлах.
9. Төсвийн төслийг хууль, журамд заасны дагуу тооцоо, судалгаа, нотлох баримтад үндэслэн бодитой төлөвлөж байх.

## ДҮГНЭЛТ

Иймд орлого, зардлыг бодитой төлөвлөж, дээр дурдсан алдаа, зөрчлийг арилган, төсвийн төлөвлөлтийн үр ашгийг сайжруулах шаардлагатай байна.

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас аймгийн 2022 оны төсвийн төсөлд төсвийн үр ашгийг сайжруулах 1.7 тэрбум төгрөг, төсвийн орлогыг нэмэгдүүлэх 1.6 тэрбум төгрөг, төсвийн зарлагыг бууруулах 2.6 тэрбум төгрөгийн санал, дүгнэлтийг хүргүүлж байна.

## ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

1. Төсвийн орлогыг нэмэгдүүлэх - 1,633.2 сая төгрөг
2. Төсвийн зарлагыг бууруулах - 2,618.5 сая төгрөгийн 34 төсөл, арга хэмжээ  
Үүнд:
  - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт - 1,504.2 сая төгрөг
  - Хөрөнгө оруулалтын бус хөтөлбөр төсөл арга хэмжээ - 497.6 сая төгрөг

- Орон нутгийн хөгжлийн сан - 38.0 сая төгрөг
  - Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал - 418.9
  - Авто замын сан – 100.0 сая төгрөг
  - Халамжийн сан – 59.8 сая төгрөг
3. Төсвийн үр ашгийг дээшлүүлэх - 1,714.8 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээ
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт - 19.5 сая төгрөг
  - Орон нутгийн хөгжлийн сан - 1,229.4 сая төгрөг
  - Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал - 215.9 сая төгрөг
  - Авто замын сан - 250.0 сая төгрөг

#### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

1. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6-д заасны дагуу аймгийн төсвийн орлогыг хянах талаар Сангийн яаманд уламжлах.
2. Хөрөнгө оруулалтын бус хөтөлбөр арга хэмжээнд ямар зардлыг хэрхэн ойлгож, төлөвлөн зарцуулах эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгон журамлах.